

**“ХҮҮХЭД, ГЭР БҮЛ, ХӨГЖИЛ ХАМГААЛАЛ”-ЫГ ДЭМЖИХ ЖИЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2024 оны 12 дугаар сарын 09

Мандалговь хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дугаар захирамжаар 2024 оныг “ХҮҮХЭД, ГЭР БҮЛ, ХӨГЖИЛ ХАМГААЛАЛ”-ЫГ дэмжих жил болгон зарлаж, жилийн ажлын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, хэрэгжилтийн талаар мэдээллээр хангахад оршино.

ХОЁР. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

“Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгаалал”-ыг дэмжих жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан аргачлалын дагуу хийлээ.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллыг дэмжих жилийн ажлын төлөвлөгөөг 5 чиглэлийн хүрээнд 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулан батлуулсан бөгөөд жилийн эцсийн хэрэгжилтийг Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газраас жилийн эцсийн байдлаар гаргаж ирүүлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилтийг 46 арга хэмжээний дундаж үнэлгээгээр тооцон гаргахад 69,7 хувьтай хэрэгжүүлэн ажилласан байна.

1. Хүүхэд, гэр бүлийн хамгааллын чиглэлээр 13 арга хэмжээ төлөвлөж 62,3 хувьтай,
2. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн чиглэлээр 10 арга хэмжээ төлөвлөж, 64 хувьтай,
3. Хүүхэд, гэр бүлийн оролцоог хангах чиглэлээр 3 арга хэмжээ төлөвлөж, 93,7 хувьтай,
4. Гэр бүл, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр 10 арга хэмжээ төлөвлөж, 81,1 хувьтай,
5. Хүүхэд, гэр бүлийн аюулгүй эсэн мэнд амьдрах орчныг бүрдүүлэх чиглэлээр 10 арга хэмжээ төлөвлөж, 66,6 хувьтай хэрэгжсэн байна. 1 арга хэмжээний хэрэгжих хугацаа болоогүй ба энэ нь Хүүхэд, гэр бүл, хөгжил, хамгаалал”-ын дэмжих жилийн

ажлын хүрээнд хийгдсэн үйл ажиллагааны үр дүнгийн видео танилцуулга бэлтгэж тайлагнах ажил байна.

ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН ОНЦЛОХ АЖЛУУД:

"Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын жил"-ийн хүрээнд иргэд, хүүхдийг зам тээврийн осол, эрсдэлээс урьдчилан сэргийлж 2024 оны сумын ОНХС-ийн хөрөнгөөр Сайнцагаан сумын Ерөнхий боловсролын Мандал, ГИЦС, Цэгцбилэг, ЭДЦС-ийн орчинд шинэлэг шийдэлтэй, цагийн тохиргоогоор ажиллах, явган хүний гэрэлтүүлэгтэй гарцын тоног төхөөрөмжийг байршууллаа.



Жайка ОУБ-ын хэрэгжүүлж буй “Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоол үйлдвэрлэлийг дэмжих төсөл”ийн үр дүнтэй танилцах туршлага солилцох арга хэмжээ болон “Хүүхдийн шим тэжээлт хоол - хоёрдугаар уралдаан”-ыг 2024 оны 04 сарын 20-ны өдөр зохион байгуулж Дундговь аймгийн 14 сумын болон Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 132, 137-р сургууль, Өвөрхангай аймгийн 4, 5 дугаар сургуулийн үдийн хоол тогооч нар зэрэг нийт 16 сум, дүүргийн 48 тогооч оролцлоо. Уг уралдааны үеэр БШУЯ, ХХААХҮЯ, ЭМЯ, БЕГ болон Нийслэлийн боловсролын хэлтсийн холбогдох мэргэжилтнүүд, Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг, Өвөрхангай аймгийн ХХААГ, ЭМГ-ын холбогдох мэргэжилтнүүд, удирдах ажилтан нар ирж туршлага судалсан байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллыг дэмжих жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилт 69,7 хувьтай буюу “Эрчимжүүлэх шаардлагатай” гэж дүгнэгдэж байна. Төр болон төрийн бус байгууллага, хүүхдийн өмнө үүрэг хүлээгчид, иргэд олон нийтийн оролцоо хамтын ажиллагааны дэмжлэгтэйгээр хүүхэд гэр бүлд чиглэсэн хөгжил хамгааллын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна гэсэн дэвшүүлсэн зорилгодоо хүрээгүй байна.

Тус онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилттэй танилцах явцад хэрэгжилтийг зөрүүтэй мэдээллээр тайлагнасан, хугацаа хоцроож тайлагнасан, нотлох баримт ирүүлээгүй, зарцуулсан төсөв тодорхойгүй, хэрэгжилтийг шат шатандаа хянаагүй ирүүлсэн зөрчлүүд түгээмэл байна.

Төлөвлөгөөний хэрэгжилтийг чиглэлээр харуулбал:

№	Агуулга	Арга хэмжээний тоо	Арга хэмжээний хэрэгжилтийн дундаж
1	Хүүхэд, гэр бүлийн хамгааллын чиглэлээр	13	62,3%
2	Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн чиглэлээр	10	64%
3	Хүүхэд, гэр бүлийн оролцоог дэмжих чиглэлээр	3	93,7%
4	Гэр бүл, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр	10	81,1%
5	Хүүхэд, гэр бүлийн аюулгүй эсэн мэнд амьдрах орчныг бүрдүүлэх чиглэлээр	11	66,6%
	Дүн	47	69,7%

Аймгийн Засаг даргын 01 дугаартай Захирамжаар дэвшүүлсэн сүүлийн 5 жилийн зорилтын мэдээлэл

Он	Дэвшүүлсэн зорилтын нэр	Арга хэмжээний тоо	Хэрэгжилт
2019	“БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИЛ”	80	89,2%
2020	“ИРГЭДИЙН АЖИЛЛАЖ, АМЬДРАХ ОРЧИН НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ ЖИЛ”	108	85%
2021	“БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ” ЖИЛ	19	90%
2022	“ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЖИЛ”	86	95%
2023	“БОЛОВСРОЛЫН ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ ДЭМЖИХ” ЖИЛ	38	88,4%
2024	“ХҮҮХЭД, ГЭР БҮЛ, ХӨГЖИЛ ХАМГААЛАЛ”-ЫГ ДЭМЖИХ ЖИЛ	47	69,7%

2024 онд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт өмнөх оны дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтээс 18,7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

УДААШРАЛТАЙ ХЭРЭГГИЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

Хэрэгжилт нь удаашралтай, үр дүнгүй хэрэгжсэн 8 арга хэмжээ байна.

- Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүний эрхийг хамгаалах “Явуулын үйлчилгээ”-г зохион байгуулах


- Хүүхдийн хөгжил, хамгааллын жилийн ажлын хүрээнд идэвх санаачилга, үр дүнтэй ажилласан байгууллага, сумдыг шалгаруулж, урамшуулах
- Хүүхдийн хөгжил, хамгааллын талаар холбогдох тооцоо судалгааг гаргаж бодлого боловсруулах ажлыг эхлүүлэх
- Олон улсын хүүхдийн ардын урлагийн “Эв нэгдэл”-ийн урлагийн наадам зохион байгуулах
- СЭМҮТ-ийн нарийн мэргэжлийн эмч нарын нээлттэй өдөрлөг зохион байгуулах
- Нийтийн эзэмшлийн гудамж талбайд 1600 гэрэлтүүлэг, 700 камержуулалтыг үе шаттай нэмэгдүүлэх,
- Спортын арга хэмжээнд хүүхдүүдийг оролцуулахдаа аюулгүй байдлыг хангасан 9 тээврийн хэрэгсэлтэй болох
- Удаан хугацаагаар ашиглагдаагүй барилгуудыг цэгцлэх ажлыг зохион байгуулах

Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийн хамт хүснэгтээр харуулбал:

№	Үйл ажиллагааны чиглэл	Төсөвлөсөн хөрөнгө /сая төгрөг		Зарцуулсан хөрөнгө /эх үүсвэр тус бүрээр/			Дүн
		УТ	ОНТ	УТ	ОНТ	ОУТ, хандив	
1	1.Хүүхэд, гэр бүлийн хамгааллын чиглэлээр:						
2	2. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн чиглэлээр						
3	3. Хүүхэд, гэр бүлийн оролцоог хангах чиглэлээр						
4	4. Гэр бүл, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр						
5	5. Хүүхэд, гэр бүлийн аюулгүй эсэн мэнд амьдрах орчныг бүрдүүлэх						
6	Дүн						

Төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 284.7 сая төгрөг зарцуулахаар төсөвлөж жилийн эцсийн байдлаар 1199.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсөвлөсөн хөрөнгийн хэмжээг зарцуулсан хөрөнгийн хэмжээтэй харьцуулан графикаар харуулбал:



ТАВ. САНАЛ ЗӨВЛӨМЖ

1. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг судлан ажилдаа мөрдөх
 2. Төлөвлөгөөний биелэлтийг гаргахдаа шалгуур үзүүлэлтийн дагуу, зорилтот түвшинд хүрсэн эсэхийг ойлгомжтой байдлаар, тоо баримттайгаар үр дүнд хүрсэн эсэхийг тодорхой байдлаар баримтжуулан тайлагнах
 3. Зарцуулсан төсвийн хэрэгжилтийг тайлагнахдаа сая. төгрөгөөр тоо баримтыг эмх цэгцтэй, эх үүсвэрийг тодорхой, тус тусад нь ялгаж тооцож тайлагнах
 4. Арга хэмжээний шалгуурыг хүрэх түвшиндээ хүрсэн эсэхийг тайланд тоон мэдээллээр тусгаж, үр дүнг тайлагнах
 5. Удаашралтай, үр дүнгүй хэрэгжиж буй арга хэмжээг хяналтдаа авч, удирдлагуудад танилцуулан, цаашид хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, эрчимжүүлж ажиллах
 6. Дараагийн 4 жилийн аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулахдаа суурь судалгаанд үндэслэн шалгуур үзүүлэлтийг томъёолж, хүрэх түвшнийг зөв тодорхойлж боловсруулах
 7. Хугацаа болоогүй байгаа болон 50 хувиас доош хэрэгжилттэй байгаа тасарч болзошгүй буюу 0 хувьтай байгаа зорилт, арга хэмжээг эрчимжүүлж ажиллах талаар харьяа агентлагууддаа чиглэл өгч ажиллах
- Цаашид төлөвлөлтийг хийхдээ зорилт, арга хэмжээ 2-ын уялдааг сайн хангах, шалгуур үзүүлэлтийг бодитой зөв томъёолох шаардлагатай байгааг онцолж байна.

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС